



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/201

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн “Барилгын захиалагчийн хяналтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 83 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт автомашин худалдан авах зардалд 150,000,000 (нэг зуун тавин сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг техник хяналтын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

8224 11 0416

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2024 оны 3 дугаар
сарын 13-ны өдрийн 460 дугаар
захирамжийн хавсралт



БАРАА НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Техникийн тодорхойлолтын хураангуй: Нийлүүлэгдэх бараа нь дор дурдсан тодорхойлолт, стандарт нийцсэн байна.

№	Тавигдах шаардлага	Үзүүлэлт
1	Ерөнхий шаардлага	Евро стандартын V8 TOYOTA LAND CRUISER-200 болон түүнтэй дүйцэх
2	Үйлдвэрлэсэн он	2013 оноос хойш үйлдвэрлэсэн
3	Моторын багтаамж	V8, 4400-аас дээш
4	Хурдны хайрцаг	Автомат
5	Жолооны хүрд	Зөв
6	Шатахууны төрөл	Бензин
7	Шатахуун зарцуулалт	100кмт 20л ба түүнээс бага
8	Дотор өнгө	Хар болон шаргал түүнтэй дүйцэхүйц
9	Хөтлөгч	Бүх дугуй 4WD
10	Дугуй	Дугуйн хээ элэгдэл 50%-аас багагүй /өвөл-4, зун-4/
11	Хаалганы тоо	5
12	Өнгө	Хар, цагаан, саарал /сэвгүй, будаггүй, замаскгүй байх/
13	Фото зураг ирүүлэх	Тендерийн материалд нийлүүлэх барааны фото зургийг өнгөтөөр ирүүлэх. /гадна 4 талаас, дотор салон/
14	Ашиглалтын хугацаа	Хяналтын км явсан. /150.000км-с илүүгүй/
15	Бусад	Иж бүрэн оношлогоонд оруулсан баримт ирүүлэх Бичиг баримтын ямар нэгэн зөрчилгүй 2023 оны татвар даатгалд бүрэн хамрагдсан байх Галын хор Эмийн сан Иж бүрэн багаж Ослын гурвалжин Дугуй хийлэгч Холбогч Домкрат Хүрз Чирэгч олс Дугуйн дорцов

Жич: Хүснэгтэнд заагдсан материалууд нь захиалагчийн ашиглаж байгаа бараа бөгөөд нийлүүлж болох бүх төрлийн материалын мэдээлэлийг ирүүлнэ.